

"Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-ын
2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн
154 дугаартай албан бичгийн 1 дүгээр хавсралт

**"БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК" ОНӨТҮГ-ЫН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ
/2023 оны жилийн эцсийн байдлаар/**

2023 оны 12 дугаар сарын 11


Багануур дүүрэг

| Д/д | Өргөдөл, гомдлын агуулга | Нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо | ШИЙДВЭРЛЭХ ШАТАНДАА БАЙГАА | | ШИЙДВЭРЛЭСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ТОО | | | | | Иргэнд хариу хүргүүлсэн хэлбэр | | | Өргөдлийн төрөл | | | | |
|-----|--|---------------------------------------|-------------------------------------|---------------------|--------------------------------------|-----------------|-----------------|---------------------|---|--------------------------------------|--------|----------------|-----------------|-------|--------|--------|----------|
| | | | ШИЙДВЭРЛЭХ ХУГАЦААНДЭВ БАЙГАА | ХУГАЦАА ХӨТӨРСӨН | 1-10 ХОНОГТ | 11-20 ХОНОГТ | 21-30 ХОНОГТ | ХУГАЦАА СУНГАСАН | ХУГАЦАА ХӨТӨРЧ ШИЙДВЭРЛЭСЭН ӨРГӨДЛИЙН ТОО | Албан бичгээр | Утсаар | Биөчлэн уулзах | Төлөрхөл | Санал | Хүсэлт | Гомдол | Мэдэгдэл |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 |
| 1 | Ажил хүссэн | | | | | | | | | | | | | | | | |
| 2 | Дэмжлэг туслалцаа хүссэн | | | | | | | | | | | | | | | | |
| 3 | Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой | | | | | | | | | | | | | | | | |
| 4 | Тухайн байгууллагын ажилтан, албан хаагчдаас гаргасан өргөдөл | 1 | | | 1 | | | | | | | + | | | + | | |
| 5 | Иргэдээс байгууллагын ажилтан, албан хаагчидтай холбоотой гаргасан өргөдөл | | | | | | | | | | | | | | | | |
| 6 | Бусад | | | | | | | | | | | | | | | | |
| | Нийт | 1 | | | 1 | | | | | | | 1 | | | 1 | | |

Өргөдлийн шийдвэрлэлтийн байдал


| № | Ангилал | Тоо | Шалтгаан, тайлбар |
|---|-----------------------------------|-----|-------------------|
| 0 | 1 | 2 | 3 |
| 1 | Иргэний талд шийдвэрлэсэн өргөдөл | 1 | - |
| 2 | Боломжгүй тухай хариу өгсөн | - | - |
| 3 | Бусад | - | - |

ХЯНАСАН:
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Д.МӨНХТОГТОХ

ТАЙЛАН ГАРГАСАН:
АРХИВ, БИЧИГ ХЭРЭГ, ГАДААД ХАРИЛЦАА
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



М.МӨНХДУЛАМ

БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК" ОНӨТҮГ-Т ИРГЭД,
АЛБАН ХААГЧДААС ИРҮҮЛСЭН ӨРГӨДЛИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН
2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 11

Багануур дүүрэг

1. Манай байгууллагад 2023 оны жилийн эцсийн байдлаар 1 албан хаагчаас цалин нэмэгдүүлэх хүсэлт гаргаж өргөдөл ирүүлсэн нь өмнөх оны тухайн үеийнхээс төрлийн хувьд харьцуулах боломжгүй, тооны хувьд цөөн байна.

Өргөдлийг өдөрт нь албан хаагчийн хүсэлт ёсоор, "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-ын даргын тушаалаар шийдвэрлэсэн.

Тайлант хугацаанд албан хаагчаас ирүүлсэн дээрх 1 өргөдлийг ERP системийн Өргөдөл, гомдол дэд хэсэгт бүртгэж, өргөдөл хяналтын картыг хөтөлж, өргөдөл болон өргөдөл хяналтын картаар хадгаламжийн нэгж үүсгэн архивлахад бэлтгэв.

Өргөдлийг хамгийн боломжит богино хугацаанд буюу ажлын 1 өдрийн дотор шийдвэрлэж байна.

2. Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй.

3. Бүтээлч санал санаачлагын шинжтэй хүсэлт илэрхийлж мэдээлэл хүссэн иргэдтэй байгууллагын удирдлага биечлэн уулзаж, Паркийн зорилго чиглэл, үйл ажиллагааны тухай тодорхой мэдээлэл, зөвлөгөө, чиглэл өгч ажилладаг. Энэ уулзалтын бүртгэлийг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд улирал бүр албан бичгээр хүргүүлдэг. 2023 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын удирдлага нийт 31 иргэнтэй уулзсан байна.

3.1. Иргэд, аж ахуйн нэгжээс гаргасан бүтээлч санал санаачлагын хүсэлтийг Паркийн үйл ажиллагаатай уялдуулан нааштайгаар шийдвэрлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангах зорилгыг хэрэгжүүлж ажилладаг. Тухайлбал, Багануур дүүрэгт төмрийн үйлдвэр барих төсөл хэрэгжүүлж байгаа МЕСЕС ХХК-тай 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдөр гэрээ байгуулсан. МЕСЕС ХХК-тай хамтран хэрэгжүүлэх Паркийн ерөнхий цахилгаан хангамжийн 6,76км урт 110кВ-ын өндөр хүчдэлийн агаарын шугамыг барих ажлын нийт 3,922.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын 45%-ийг тус компаниас, 55%-ийг нийслэлийн төсвөөс шийдвэрлүүлэхээр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт талаас уг ажлыг гүйцэтгэх бэлтгэл ажлыг ханган ажилласан. Улмаар МЕСЕС ХХК-ийн зүгээс 526,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар суурийн барилгын ажил хийх хүрээнд 500.0 сая төгрөгийн бетон болон төмөр тулгуур бэлтгэх ажил хийгдээд байна.

3.2. "Импактор Капитал Менежмент Монголия" ХХК-иас Паркийн хүрээнд, уурхайн хаягдал нүүрсийг ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслийн санал ирүүлснээр Паркийн Хүнд үйлдвэрлэлийн бүсэд Казахстан, Герман, Монгол Улсын хөрөнгө оруулалтаар төсөл хэрэгжүүлэх "Импактор Капитал Менежмент Монголия" ХХК-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд цахим болон нүүр тулсан уулзалтууд зохион байгуулж, уг төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын талаар зөвшилцсөн. Төсөл хэрэгжүүлэх хүрээнд Казахстан Улсаас инженерийн баг ирж Улаанбаатар хотод ажилласан. 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдөр төслийн баг Багануур үйлдвэрлэл, технологийн паркад ирж ажилласан.

Дээрх саналын дагуу үе шаттай хэлэлцээр хийгдэж байна. 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдөр болон 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Монгол Улсын Засгийн газарт Ерөнхий сайдын ажлын алба мөн "Эрдэнэс Монгол" ХК-д хүнд үйлдвэрийн бүсэд хэрэгжүүлэх төслийн талаар танилцуулж, хүсэлт хүргүүлсэн бөгөөд Монголын талаас дэмжих шийдвэр гарсан нөхцөлд төсөл санхүүжүүлэгч Германы ICMD компани өөрийн хөрөнгө оруулалтаар төслийн хүрээнд байгуулагдах дэд станцыг барих санал, шинэчилсэн мэдээлэл, төслийн урьдчилсан ТЭЗҮ-г дахин танилцуулсан. Төслийг хэрэгжүүлэх асуудлаар тус компанитай удаа дараа албан бичиг солилцож, уулзалт хийж зөвшилцлийг үргэлжлүүлэн явуулж байна.

4.Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээ, тайланг байгууллагын цахим хуудасны ил тод байдал хэсэгт улирал бүр нээлттэй байршуулан ажиллаж байна.

5.Иргэдээс манай байгууллагын ажилтан, албан хаагчийн ёс зүй, харилцаа, хандлагатай холбоотой гаргасан өргөдөл, гомдол байхгүй.

ХЯНАСАН:
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Д.МӨНХТОГТОХ

ТАЙЛАН ГАРГАСАН:
ГАДААД ХАРИЛЦАА, БИЧИГ ХЭРЭГ, АРХИВ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

 М.МӨНХДУЛАМ